



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 2/636

Есөнбулаг

Мотоциклын хөдөлгөөнийг түр
хугацаагаар хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.10 дахь заалт, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулан замын зорчих хэсэгт халтиргаа гулгаа үүсэж болзошгүй нөхцөл байдалтай байгаа тул механикжсан тээврийн хэрэгсэл буюу мотоциклоор замын хөдөлгөөнд оролцогчдын эрүүл мэнд, амь насанд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор аймаг болон сумдын суурин газарт мотоциклоор замын хөдөлгөөнд оролцохыг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрийг дуустал түр хугацаанд хориглосугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, илэрсэн зөрчлийг арилгуулах, иргэдэд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга, сэрэмжлүүлгийг хүргэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Н.Мэндбаяр)-д, Сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Мягмарсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ